

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2019 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

01

ТОРИЙН АУДИТИН БАЙГУУЛЛАГА
**ЗСРЧИЛГҮЙ
САНЛЫ ДУГНЭЛТ**

Агуулга

1. Аудитын гэрчилгээ	2
2. Аудитын тайлан	4
2.1. Оршил	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	5
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	5
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	6
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	7
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	7
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	8
2.12. Шилэн дансны мэдээлэл	8
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	8
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	8
3. Менежментийн захидал	9
4. Аудит хийсэн санхүүгийн тайлан	12
4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	12
4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	13
4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	15
4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	17
4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	18
4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	20
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	21

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт



НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ
ГАЗРЫН ДАРГА Д.ЗОРИГТ ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас: 26-04-37, Факс: 51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2020. 02. 24 № 06/602
танай -ны № -т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар НДЕГ-ын 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагын мөрдэж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дунд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага


Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бodoх бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бodoх бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.НАРАНЧИМЭГ



2. Аудитын тайлан

2.1. Оршил

Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг тус байгууллагын дарга Д.Зоригт танд танилцуулж байна.

Энэхүү тайланда үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн тайлант онд болон он удаан жил болсон авлага болон татварын өглөгийг барагдуулах, ашиглагдахгүй үндсэн хөрөнгийг холбогдох байгууллагад хандаж шийдвэрлэх, бэлэн мөнгөний зарцуулалтад тавих хяналтыг сайжруулах талаар өгсөн зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийллээ.

Тус байгууллагын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 01 дүгээр сарын 30-наас 02 дугаар сарын 20-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 21-ний өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Санхүүгийн аудитын газрын аудитор Б.Долгоржав хариуцаж хэрэгжүүлэв.

Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 1/151 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланда аудит хийх журам, баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалыар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Нийгмийн даатгалын ерөнхий газар нь даатгуулагчийнхаа итгэл найдвар, сэтгэл ханамжаар үнэлэгдэх нийгмийн даатгалын үйлчилгээг хүргэх эрхэм зорилготой ажилладаг бөгөөд 2030 он гэхэд бүх нийтийн насан туршийн нийгмийн баталгааг хангахуйц чадамжтай, нийгмийн даатгалын цогц үйлчилгээ бүхий даатгагч болох гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлсон байна.

Нийгмийн даатгалын байгууллага есөн дэвших эрмэлзэлтэй мэргэшсэн, чадварлаг, ёс зүйтэй хүний нөөцөд түшиглэн үйл ажиллагаагаа цаг үргэлжид сайжруулан, түншлэл хамтын ажиллагааг дэмжин, харилцан үр ашигтай хамтран ажиллаж, сайн засаглалыг хэрэгжүүлэн хэрэгцээ шаардлагад нийцсэн чанартай үйлчилгээг даатгуулагчдад хүргэхээр үйл ажиллагаагаа чиглүүлэн ажилладаг байна.

Байгууллагын үйл ажиллагааг зохицуулж байгаа эрх зүйн орчинд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй байна.

2.5. Нягтлан бodoх бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дotoод хяналттай холбоотой хучин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бodoх бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дotoод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстай гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Нийгмийн даатгалын ерөнхий газрын мөрдөж байгаа Нягтлан бodoх бүртгэлийн бодлогын баримт бичгийг 2018 онд шинэчлэн баталсан бөгөөд Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бodoх бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Тус байгууллага санхүү, нягтлан бodoх бүртгэлийн үйл ажиллагаанд НДЕГ-ын харьяа Мэдээллийн технологийн төвийн 2007 онд зохиосон нягтлан бodoх бүртгэлийн “Санхүү” программ хангамж ашиглан санхүүгийн тайланг бэлтгэсэн байна. Санхүүгийн программ Сангийн сайдын баталсан эдийн засгийн ангиллын дагуу боловсруулахгүй байгаа нь шаардлага хангахгүй байна.

Нийгмийн даатгалын ерөнхий газрын дotoод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дotoод хяналт үр нөлөөгүй гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Нийгмийн даатгалын ерөнхий газрын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дotoод орчин, дotoод хяналтыг судлан, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 12 эрсдэлтэй асуудал тодорхойлж түүнд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж, баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөлтийн үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2018 оны санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэл бага гэж үнэлэн 2 хувиар тогтоосон.

Төлөвлөлтийн үе шатанд 2018 оны санхүүгийн тайлангийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 7,528,902.6 мянган төгрөгийн 2 хувь 150,578.1 мянган төгрөгөөр материаллаг байдлын түвшнийг тодорхойлж, баталгаажууллаа.

**Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
санхүүгийн тайлангийн аудит**

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 79,598.0 мянган төгрөгөөр тогтоосон нь 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн суурь үзүүлэлт буюу үр дүнгийн нийт зардлаас тооцоолсонтой холбоотой болно.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд БНСУ дахь Нийгмийн даатгалын албаны санхүүгийн тайлан нэгтгэгдэн тайлагнадаг байна. НДЕГ-ын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 226,003.9 мянган төгрөгөөр буюу 3.7 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөг/	
			Өөрчлөлт	
Мөнгөн хөрөнгө	122,665.4	80,451.4	(42,214.0)	
Авлага	57,490.3	56,184.5	(1,305.8)	
Урьдчилгаа	0.0	0.0	0.0	
Бараа материал	100,018.3	66,722.5	33,295.8	
Үндсэн хөрөнгө	5,811,646.9	5,662,458.7	(149,188.2)	
Нийт хөрөнгө	6,091,820.9	5,865,817.0	(232,953.5)	
Өр төлбөр	5,092.2	12,041.8	6,949.6	
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	6,086,728.7	5,853,775.2	0.0	
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	6,091,820.9	5,865,817.0	(226,003.9)	

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 122,665.4 мянган төгрөг байснаас эцсийн үлдэгдэл 80,451.4 мянган төгрөг болж 42,214.0 мянган төгрөгөөр буурсан бөгөөд ахмадын сангийн дансанд 58,128.8 мянга, нэмэлт санхүүжилтийн дансанд 22,322.6 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Авлагын үлдэгдэл өмнөх оноос 1,305.8 мянган төгрөгөөр буурсан нь татварын албанаас авах авлагыг барагдуулсантай холбоотой байна. Нийт авлагын үлдэгдлийн 97.0 хувь буюу 54,510.0 мянган төгрөг БНСУ дахь Нийгмийн даатгалын албаны ажиллагсдын байрны барьцааны мөнгө, үндсэн 3.0 хувь буюу НДЕГ-ын 1,674.5 мянган төгрөгийн авлага, үүнээс 714.5 мянган төгрөгийн ажиллагсдаас авах авлага, 960.0 мянган төгрөгийн тайлант хугацаанд үүссэн түрээсийн орлогын авлага байна.

Тайлант хугацаанд бараа материал 120,805.0 мянган төгрөгөөр худалдан авч, 102,592.8 мянга төгрөгийн материал зарцуулснаас 66,722.5 мянган төгрөгийн үлдэгдэлтэй буюу өмнөх оноос 33,295.8 мянган төгрөгөөр буурсан байна. 2019 онд бичиг хэрэг 1,616.3 мянга, сэлбэг хэрэгсэл 297.6 мянган төгрөгөөр нэмэгдэж, аж ахуйн материал 35,083.3 мянган төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна.

Бараа материалын үлдэгдлийн 98.1 хувь буюу 65,549.6 мянган төгрөгийн хөрөнгө нь НДЕГ, 1.9 хувь буюу 1,299.2 мянган төгрөгийн хөрөнгө нь БНСУ дахь Нийгмийн даатгалын албаных байна.

Бараа материалын үлдэгдэлд бичиг хэрэг 14.7 хувь буюу 9,801.0 мянга, аж ахуйн материал буюу ашиглалтад байгаа хангамжийн материал 73.4 хувь буюу 48,967.0 мянга, сэлбэг хэрэгсэл 11.9 хувь буюу 7,954.5 мянган төгрөгийн бараа материал эзэлж байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл өмнөх оноос 149,188.2 мянган төгрөгөөр буурсан нь тайлант хугацааны хөрөнгийн хуримтлагдсан элэгдэлтэй холбоотой байна.

Тайлант хугацаанд үндсэн хөрөнгө 246,678.3 мянган төгрөгөөр нэмэгдэж, 47,953.2 мянга төгрөгөөр хасагдсанаар өмнөх оноос хөрөнгө 198,725.1 мянган төгрөгөөр өсөж, 348,039.6 мянган төгрөгийн хөрөнгийн элэгдлээр буурсан байна.

ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тогтоолыг үндэслэн 2019 оны А-1/2436 дугаар “Зөвшөөрөл олгох тухай” албан бичгээр 40,500.0 мянган төгрөгийн автомашин, Азийн хөгжлийн банкны “Хүнс

тэжээл, нийгмийн халамжийн нэмэлт санхүүжилт төслийн хуваарилалтаар дараах хөрөнгүүд нийлүүлэгдсэн байна. Үүнд НДЕГ-ын даргын 2019 оны А/162 дугаар “Программ хангамж, тоног төхөөрөмж хуваарилах тухай” тушаалаар 102,107.0 мянган төгрөгийн программ хангамж, 55,959.9 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 2019 оны А/202 дугаар тушаалаар 5,776.2 мянган төгрөгийн тоног төхөөрөмж нийт 166,212.6 мянга, дотоод шилжүүлгээр 2,369.8 мянган төгрөгийн хөрөнгө тус тус нэмэгдсэн байна. Мөн аудитаар бараа материалын данснаас 25,992.2 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 14,099.4 мянган төгрөгийн тавилга, үндсэн хөрөнгийн дансанд нийт 40,091.6 мянган төгрөгийн залруулга хийлгэлээ.

ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тогтоолыг үндэслэн А-1/4239, А-1/4240 дүгээр “Зөвшөөрөл олгох тухай” албан бичиг, НДЕГ-ын даргын 2019 оны А/198 дугаар “Үндсэн хөрөнгө актлах, шилжүүлэх тухай” тушаалаар 15,538.4 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 7,629.8 мянган төгрөгийн тавилга акталж, 24,785.0 мянган төгрөгийн тавилгыг салбар хэлтсүүдэд шилжүүлэн нийт 47,953.2 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг данс, бүртгэлээс хассан байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл өмнөх оноос 6,949.7 мянган төгрөгөөр өссөн нь НДЕГ, БНСУ дахь Нийгмийн даатгалын албаны ХАОАТ-ын хоорондын тооцоог дутуу хийснээс татварын албанд өглөг үүссэнээс шалтгаалжээ.

2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрт зориулсан 3,145,678.2 мянган төгрөгийг баталснаас 3,013,580.2 мянган төгрөгийг Нийгмийн даатгалын сангийн төсвөөс, 132,098.0 мянган төгрөгийг туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ. Нийгмийн даатгалын сангаас 3,013,580.2 мянган төгрөгийн санхүүжилтийг бүрэн олгосон байна.

Туслах үйл ажиллагааны орлого 132,098.0 мянган төгрөг бүрдүүлэхээс 112,461.1 мянган төгрөгийн орлого бүрдэж 19,636.9 мянган төгрөгөөр тасарсан нь ТӨБЗГ-т түрээсийн орлогын 30 хувийг төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 3,103,381.3 мянган төгрөг буюу 98.6 хувьтай ба зарцуулаагүй үлдэгдэл 42,342.5 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Нэмэлт төсөв: Азийн хөгжлийн банкны санхүүжилттэй “Хүнс тэжээл, нийгмийн халамжийн төсөл”-өөс 200,285.0 мянга, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрөөс 20,2000.0 мянга, Нийгмийн даатгалын сангаас 83,146.2 мянга, нийт 303,431.2 мянган төгрөгийн орлогыг нэмэлт төсвөөр санхүүжигджээ.

Нэмэлт санхүүжилтээс Хүнс тэжээл, нийгмийн халамжийн төслийн хөрөнгийг салбарын ажилчдын чадавхыг сайжруулах сургалтад 92,769.3 мянга, Нийгмийн даатгалын сангийн нэмэлт санхүүжилтийг нэг удаагийн буцалтгүй тусlamж 35,646.2 мянга, цалин 38,500.0 мянга, томилолт 2,000.0 мянга нийт 166,915.5 мянган төгрөг зарцуулжээ. Нийгмийн даатгалын санд 116,357.7 мянган төгрөг төвлөрүүлж, үлдэгдэл 22,158.0 мянган төгрөгийг орон нутгийн ажиллагсдын чадавхи сайжруулах сургалтад зарцуулахаар төлөвлөсөн байна.

2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 12 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 5 эрсдэл тодорхойлж нийт 17 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 237,947.3 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 158,683.0 мянган төгрөгийн алдааг залруулж, 79,264.3 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 7 зөвлөмж өглөө. Үүнд:

Бараа материалын дансанд үндсэн хөрөнгийн шинжтэй 40,091.6 мянган төгрөгийн шинжтэй хөрөнгө бүртгэсэн, төсвийн гүйцэтгэлийн тайлангийн санхүүжилтийн эх үүсвэрийг 19,591.4 мянга, нийт зарлага ба цэвэр зээлийн дүнг 99,000.0 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлэгдсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах” гэсэн заалттай нийцэхгүй, тодруулга ба толилуулга, үнэн зөв батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланд 158,683.0 мянган төгрөгийн залруулга хийлгэв.

Залруулагдаагүй 79,264.3 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 7 зөвлөмж өгснийг менежментийн захидалд тусгалаа.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Азийн хөгжлийн банкны санхүүжилттэй “Хүнс тэжээл, нийгмийн халамжийн төсөл”-ийн хөрөнгөөр бэлтгэсэн 803,980.5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг НДЕГ-ын харьяа байгууллагуудад шилжүүлснийг данс бүртгэлд тусгасан эсэхийг НДС-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангаар авч үзнэ.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Нийгмийн даатгалын ерөнхий газар шилэн данс цахим хуудсанд тайлант хугацаанд Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 134 мэдээллийг хугацаанд нь, 13 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 6,699.1 мянган төгрөгийн зөрчилд 4,422.6 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 1 албан шаардлага, 2 зөвлөмжийн хэрэгжилт 100 хувь байна.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Залруулагдаагүй 79,264.3 мянган төгрөгийн алдаа, зөрчил нь бидний тогтоосон 79,598.0 мянган төгрөгийн материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул зөрчилгүй дүгнэлт өгч байна.

Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар илрүүлсэн залруулагдаагүй буруу илэрхийлийн санхүүгийн тайланд үзүүлэх үр нөлөөгт эс тооцвол 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн байна.

3.Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидалыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидалын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруултын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Өглөг данстай холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт:

Өр төлбөрийн тооцоог буруу хийснээс жилийн эцэст 6,949.7 мянган төгрөгийн өр үүсгэсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэсэн заалт, УСНББОУС-28-ын заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.1.2 Эрсдэл:

Өглөгийг тооцоо нийлж, актаар баталгаажуулаагүй байх

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Тооцоог зөв хийж байх, өглөгийг барагдуулах, дотоод хяналтыг сайжруулах

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Зөрчлийг хүлээн зөвшөөрч, өглөгийг 2020 оны эхний улиралд багтаан барагдуулахаар болов.

3.2 Биет бус хөрөнгөтэй холбоотой асуудал

3.2.1. Илрүүлэлт:

Ашиглалтгүй болсон 150.0 мянган төгрөгийн программыг данс бүртгэлээс хасаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэсэн заалттай нийцэхгүй, оршин байх, тодруулга ба толилуулга батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.2.2. Эрсдэл:

Үндсэн хөрөнгө шамшигдах, санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх

3.2.3. Өгсөн зөвлөмж:

Ашиглагдахгүй байгаа хөрөнгийг холбогдох байгууллагад хандаж шийдвэрлэх, цаашид хөрөнгийн бүртгэл, ашиглалтад хяналт тавих

3.2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Зөрчлийг хүлээн зөвшөөрч, программыг ТӨБЗГ-ын зөвшөөрлийн дагуу шийдвэрлэхээр болов.

3.3 Шатахууны зарцуулалттай холбоотой асуудал

3.3.1. Илрүүлэлт:

Касст бэлнээр зарцуулсан 14,382.3 мянган төгрөгийн шатахууны зарцуулалтын баримт нь цаг хугацааны хувьд тохирохгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно" гэсэн заалт, УСНББОУС-28 заалттай нийцэхгүй, иж бүрэн байх, тохиолдсон байх, үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.3.2. Эрсдэл:

Төсвийн хөрөнгө үр ашиггүй зарцуулах

3.3.3. Өгсөн зөвлөмж:

Кассын бэлэн мөнгөний зарцуулалт болон анхан шатны баримтад тавих хяналтыг сайжруулах, төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журмыг хэрэгжүүлж ажиллах.

3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Цаашид анхан шатны баримтын бүрдүүлэлтэд анхаарч ажиллана.

3.4 Мөнгөн хөрөнгийн зарцуулалттай холбоотой асуудал

3.4.1. Илрүүлэлт:

Бэлэн мөнгөний зарцуулалт өндөр байгаа нь төсөвт байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журмыг хэрэгжүүлдэггүй нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам"-ын 2.5-д "Төсвийн байгууллага бэлэн мөнгөөр болон арилжааны банкны төлбөрийн картаар зарлага хийхдээ зарцуулалтын эрхийн хүрээнд зөвшөөрөгдсөн төсвийн хуваарийн дагуу гүйцэтгэх бөгөөд Төрийн сангаас тухайн байгууллагын дотоод үйл ажиллагааны хэрэгцээ шаардлагад нийцүүлэн баталж өгсөн жижиг мөнгөн сангийн /цаашид "ЖМС" гэх/ хязгаарыг дагаж мөрдөнө", 6.3-д "Төсвийн байгууллага нь бага хэмжээний үнийн дүнтэй бараа, ажил үйлчилгээний болон банкны харилцах дансгүй этгээдийн төлбөрийг бэлэн мөнгөөр гүйцэтгэх ба бараа, ажил үйлчилгээний төлбөрийн нийт дүн нь 300,000 (гурван зуун мянган) төгрөг, тээвэр шатахууны хэмжээ-500,000(таван зуун мянган) төгрөгөөс хэтрэхгүй байна" гэсэн заалт, УСНББОУСтандарт 2-ын заалттай нийцэхгүй, үнэн зөв, тохиолдсон байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.4.2. Эрсдэл:

Төсвийн хөрөнгө үр ашиггүй, үргүй зардал гаргах, санхүүгийн сахилга алдагдах

3.4.3. Өгсөн зөвлөмж:

Бэлэн мөнгөний зарцуулалтын хэмжээг багасгах, зарцуулалтад тавих хяналтыг сайжруулах

3.4.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Цаашид бэлэн мөнгөөр томилолт, зам хоногийн мөнгийг олгохгүй байхаар анхаарч ажиллана.

3.5 Ахмадын сантай холбоотой асуудал

3.5.1. Илрүүлэлт:

Тайлант хугацаанд зарцуулагдах зардлаас хэмнэсэн 36,922.9 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлэлгүй Ахмадын сангийн дансанд байршуулсан нь Засгийн газрын 2017 оны 197 дугаар тогтоолоор баталсан "Ахмадын сан байгуулан ажиллуулах журам"-ын 1.3-т "Төсөвт байгууллагын тухайд цалингийн сангийн гурав хүртэлх хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр сан байгуулж, шаардагдах хөрөнгийг төсөвтөө жил бүр тусгана", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 7 дугаар зүйлийн

7.7-д "Энэ хуулийн 43 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд төсвийн захирагчийн төсвийн зарцуулаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ" гэсэн заалт, УСНББОУСтандарт 15-ын заалттай нийцэхгүй, иж бүрэн байх, үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.5.2. Эрсдэл:

Төсвийг зориулалтын дагуу зарцуулаагүй байх

3.5.3. Өгсөн зөвлөмж:

Ахмадын санд зарцуулах хөрөнгийг батлуулж хэрэгжүүлэх

3.5.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Ахмадын сангийн төсвийг батлуулах санал хүргүүлнэ.

3.6 Авлага данстай холбоотой асуудал

3.6.1. Илрүүлэлт:

Авлага дансны үлдэгдэлд байгаа 2009-2016 онд үүссэн ажиллагдаас авах 20,859.4 мянган төгрөгийн авлагыг барагдуулаагүй нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэсэн заалт, УСНББОУСтандарт 28-ын заалттай нийцэхгүй, эрх ба үүрэг, үнэн зөв батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.6.2. Эрсдэл:

Авлагыг баталгаажуулаагүйгээс найдваргүй авлага үүсэх, хөрөнгө шамшигдах

3.6.3. Өгсөн зөвлөмж:

Авлагыг барагдуулах арга хэмжээ авах

3.6.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Холбогдох ажилтнуудаар төлүүлэхээр арга хэмжээ авч ажиллана.

3.7 Санхүүгийн тайлантай холбоотой асуудал

3.7.1. Илрүүлэлт:

БНСУ дахь Нийгмийн даатгалын алба, ахмадын сангийн санхүүгийн тайланг тусад нь бэлтгээгүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2-д "санхүүгийн аливаа үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу, цаг хугацаанд нь, үнэн зөв, үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлэн бүртгэж, тайлагнах", 16 дугаар зүйлийн 16.5.7-д "байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах" гэсэн заалттай нийцэхгүй, эрх ба үүрэг, үнэн зөв батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.7.2. Эрсдэл:

Төсвийн санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх

3.7.3. Өгсөн зөвлөмж:

БНСУ дахь Нийгмийн даатгалын алба, ахмадын сангийн санхүүгийн тайланг тусад нь тайлагнаж байх

3.7.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Байгууллагын удирдлагад танилцуулсан ба цаашид анхаарч ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4.Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

